



Хүн ам, орон сууцны тооллого явуулах мэдэгдэл



Япон улсын засгийн газар 2020 оны 10-р сарын 1-ний өдрийн байдлаар хүн ам, орон сууцны тооллого явуулна.

9-р сарын дунд үеэс эхлэн, тоологч тооллогын маягт тараахаар таны гэрт очно.

Хүн ам, орон сууцны тооллогын үр дүн нь гадаад иргэдийн амьдрахад таатай нийгмийн орчин, хот байгуулалт гэх мэтийн арга хэмжээнд ашиглагддаг юм.

Хүн ам, орон сууцны тооллого нь иргэншлээс үл хамааран Япон улсад 3 сараас дээш хугацаанд оршин сууж буй, эсвэл оршин суухаар төлөвлөж буй хүмүүст зориулагдсан болно.

Хамрагдах хүн нь хариулт өгөх үүрэгтэй тул, заавал хариулана уу.

Бөглөсөн хариулт нь зөвхөн статистикийн зорилгот ашиглагдах бөгөөд оршин суухыг хянах, цагдан сэргийлэх албанаас эрж, хайх гэх мэт бусад зорилгоор ашиглагдахгүй болно.

Хүн ам, орон сууцны тооллого нь цахимаар хариулах боломжтой.

10-р сарын 7-ны лхагва гариг хүртэл цахимаар хариулж болно.

※Цахим хариулт нь Япон, Англи, Хятад/хялбаршуулсан, уламжлалт бичиглэл/, Солонгос, Вьетнам, Испани, Португал хэлээр бөглөх боломжтой.

10-р сарын 7 (Лхагва гараг) өдөр хүртэл хариулаагүй бол тоологч таны гэрт очиж тооллогын маягтыг бөглүүлж авах болно.

Хэрэв та тооллогын маягт хэрхэн бөглөхөө мэдэхгүй, эсвэл тооллогын маягт аваагүй байгаа бол хүн ам, орон сууцны тооллогын лавлах утас руу холбогдоно уу.

2020 оны хүн ам, орон сууцны тооллогын нэгдсэн цахим хуудас

<https://www.kokusei2020.go.jp/>

Монгол хэлний тооллогын тухай тайлбарыг 9-р сарын 1-ний мягмар гаригаас эхлэн, доорх QR код эсвэл холбоосоос харах боломжтой.

<https://www.kokusei2020.go.jp/household/language/mongolian.html>



Хүн ам, орон сууцны тооллогын лавлах утас: 0570-07-2020

Үйлчлэх хугацаа: 9-р сарын 7 даваа гаригаас 10-р сарын 31 бямба гариг хүртэл

Үйлчилгээний цаг: 8 цагаас 21 цаг хүртэл

※Оператор нь Япон хэлээр хандах боловч гадаад хэлээр хандах мөн боломжтой.

国勢調査
2020